



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/125

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 48.2.6 дахь заалт, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 05 дугаар “Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Сумын өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Худалдан авах
ажиллаганы газрын дарга)

Гишүүд:

Б.Хорол

(Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хөгжлийн бодлого
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн)

А.Аасүрэн

(Аймгийн Орон нутгийн өмчийн
газрын Нягтлан бодогч)

Хөндлөнгийн төлөөлөл:

Б.Базаррагчаа

(Сумын 1 дүгээр багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг

42124 300

төлөвлөлт, худалдаа авах
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.СУГАРМАА